



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар

6/20

Номгон

Г Өлзийт сумын төвийн хөгжлийн ерөнхий Г
төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай

Сумын төвд дэд бүтэц иж бүрэн хэрэгжсэний үндсэн дээр иргэдийн орон сууц барих зайлшгүй шаардлагын дагуу нам давхрын орон сууцны бүс (А)-ээр батлагдсан газрын хилийг өөрчлөх, мөн үйлдвэрлэлийн бүсийг гэр хорооллын газар болгон дахин төлөвлөлт оруулах шаардлагатай байгаа санал ирүүлснийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 35 дугаар зүйлийн 35.1.13, 48 дугаар зүйлийн 48.1, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон сууцны бүс (А)-ээр батлагдсан газрын хилийг өөрчлөх, үйлдвэрлэлийн бүсийг гэр хорооллын газар болгон дахин төлөвлөлт болгох саналыг дэмжин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 дүгээр 13-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “Өлзийт сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд өөрчлөлт оруулж, хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан зураг төсвийн дагуу бүтээн байгуулалтын ажлыг хууль тогтоомжийн хүрээнд шуурхай, ил тод байдлыг хангаж зохион байгуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Байгальмаа)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

D;2025on;togtool2025

642501008

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 6/20
дугаар тогтоолын хавсралт

